



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 198

Мандалговь

“Мандалшилтгээн” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/90 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мандалшилтгээн” ХХК-тай 199,589,885 (нэг зуун ерөн есөн сая таван зуун наян есөн мянга найман зуун наян тав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу Аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандалшилтгээн” ХХК-ний захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАН



480410801